



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 232

Улаанбаатар хот

### Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Орхон аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 74,760,000.00 (далан дөрвөн сая долоон зуун жаран мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож Улсын хоёрдугаар төв эмнэлэгт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Орхон аймгийн Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн захирал Х.Төгсбаяр, Улсын хоёрдугаар төв эмнэлгийн ерөнхий захирлын албан үүрийг түр орлон гүйцэтгэгч Б.Эрдэнэбулган нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Тээврийн хэрэгслийг Улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132004060  
32-р хүрэлдаан

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн  
88 дугаар тогтоолын хавсралт

ОРХОН АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, УЛСЫН  
ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛЭГТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Шинэчлэн тогтоосон үнэ	Цаашид ашиглах хугацаа (жил)
			(төгрөг)				
1	Hyundai, County автобус, 1154 ОРО, KMJHG17FPDC060515	2013/2013	74,760,000.00	74,760,000.00	-	20,000,000.00	4
Нийт дүн			74,760,000.00	74,760,000.00	-	20,000,000.00	-
Нийт дүн			(далан дөрвөн сая долоон зуун жаран мянган)		-	(хорин сая)	-